



№

(БТКУС код 84.28)

**№ 9.6.1 ЛИФТ, КРАН, КОНВЕЙЕР ЗЭРЭГ  
ӨРГӨХ БАЙГУУЛАМЖИЙГ ИМПОРТЛОХ  
ҮЕИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Импортологчийн нэр:

Регистрийн дугаар:

№	Хууль тогтоомжийн нэр, заалт	Шаардлага	Шаардлага хангасан эсэх	
			тийм	үгүй
1	СТЗТҮИТ хуулийн 13.2, 14.2, 14.7 заалт, ЭАТ хуулийн 8.1, 8.3 заалт, ТББҮМУЗЗНУХН журмын 1.7, 3.1, 3.2.5, 3.5 заалт.	ILAC, IAF, ADAC зэрэг олон улсын конвенци, гэрээ хэлэлцээрээр нэгдэн орсон гишүүн орнуудын тохирлын үнэлгээний байгууллагаас олгосон гэрчилгээтэй. (Хэрэв тухайн өргөх байгууламж нь дээрх тэмдэг бүхий гэрчилгээгүй зөвхөн тухайн орны бүтээгдэхүүний гэрчилгээтэй бол Монгол улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаас олгосон тохирлын гэрчилгээ авсан байх.)		
2	ХЭХТ хуулийн 11.1, 12.2 заалт.	Лифтийг нийлүүлэгч, барилгын захиалагч байгууллагатай байгуулсан худалдах, худалдан авах гэрээ эсвэл түүнтэй адилтгах баримт бичигтэй		
3		Лифтийг нийлүүлэгч, үйлдвэрлэгч байгууллагатай байгуулсан захиалгын гэрээ эсвэл түүнтэй адилтгах баримт бичигтэй		
4	ААҮАТЗТ хуулийн 15.14.3 заалт, АӨКТААД-ийн 2.1.1 заалт.	Лифт, цамхагт, вандан, гүүрэн краныг дистрибьюторын гэрээгээр нийлүүлж, угсралт болон засвар үйлчилгээний ажлыг эрхлэх мэргэжлийн байгууллагын гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн (лифт-4.1, 5.1, кран-4.2, 5.2) хуулбартай		
5	ХАБЭАТ хуулийн 9.1.2, 10.3 заалт, ЛТААД-ийн 1.9 заалт, АӨКТААД-ийн 4.3 заалт.	Өргөх байгууламжийн гарал үүслийн бичиг болон техникийн паспорт түүнтэй адилтгах баримт бичигтэй		
6		Өргөх байгууламжийн иж бүрдлийг батлах эд ангийн жагсаалт эсвэл түүнтэй адилтгах баримт бичигтэй		

**II. БИЕТ ҮЗЛЭГ ШАЛГАЛТ**

Эхэлсэн: 20\_\_ он \_\_ сар \_\_ өдөр, \_\_ цаг \_\_ мин; Дууссан: 20\_\_ он \_\_ сар \_\_ өдөр, \_\_ цаг \_\_ мин;

Тээвэрлэлт, сав баглаа, боодол, хаяг шошгод тавигдах шаардлага

7	ХАБЭАТ хуулийн 9.1.2, 10.3 заалт, ЛТААД-ийн 1.9 заалт, АӨКТААД-ийн 4.3 заалт.	Бүтээгдэхүүний тоо хэмжээ, төлөв байдал нь дагалдах баримт бичигт заасан мэдээлэлтэй нийцсэн.		
8	ХЭХТ хуулийн 13.2 заалт.	Чанарын шаардлага хангасан зориулалтын сав, баглаа, боодол, хаяг, үйлдвэрлэгчийн тэмдэглэгээ шошго нь нүдэнд тусах газарт, ойлгомжтой, гаргацтай, амархан арилахааргүй бичигдсэн		
9	ЭАТ хуулийн 8.5 заалт,	Хадгалах нөхцөл, тээвэрлэх арга (зөвхөн дээш харуулах, хагарах шил, давхарлан хураах тоо, гм) бичигдсэн		

## БАТАЛГААЖУУЛАЛТ

- |                                                                                                  |                                                                                    |
|--------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|
| <input type="checkbox"/> Хяналтаас чөлөөлөх<br><input type="checkbox"/> Гүний хяналтад шилжүүлэх | <input type="checkbox"/> Саатуулах<br><input type="checkbox"/> Шийтгэвэр ногдуулах |
|--------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|

Хяналт хийсэн улсын /ахлах/ Овог, нэр:  Гарын үсэг:  Овог, нэр:  Гарын үсэг:  <div style="text-align: right;">/тэмдэг/</div>	Хүлээн зөвшөөрсөн Албан тушаал:  Овог, нэр: <span style="float: right;">РД: <table border="1" style="display: inline-table; border-collapse: collapse;"><tr><td style="width: 15px; height: 15px;"></td><td style="width: 15px; height: 15px;"></td><td style="width: 15px; height: 15px;"></td><td style="width: 15px; height: 15px;"></td><td style="width: 15px; height: 15px;"></td><td style="width: 15px; height: 15px;"></td></tr></table></span>  Утас: <span style="float: right;">Гарын үсэг:</span>						

### Товчилсон үгийн тайлал:

1	<p><b>Эрүүл ахуйн тухай хуулийн заалт: 8.1.</b> Түүхий эд, бараа, бүтээгдэхүүн, бодис, бэлдмэл, тэдгээрийн сав, баглаа боодол, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь Монгол Улсын болон олон улсын стандарт, норматив, техникийн баримт бичиг, эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна. <b>8.3.</b> Экспортлох, импортлох түүхий эд, бараа, бүтээгдэхүүн, бодис, бэлдмэл, техник, технологи нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан болохыг нотлох эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээтэй байна. <b>8.5.</b> Бараа, бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг эрүүл ахуйн шаардлагын дагуу хадгалж, зориулалтын тээврийн хэрэгслэлээр тээвэрлэнэ.</p>
2	<p><b>Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн заалт: 13.2.</b> Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна. <b>14.2.</b> Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрнө. <b>14.7.</b> Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 14.2-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт, тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй.</p>
3	<p><b>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.14.3. заалт:</b> - цахилгаан шат (лифт), өргөх краны угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;</p>
4	<p><b>Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журмын 1.7. заалт:</b> Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрсөн тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээтэй, мөн хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй. <b>3.1.</b> Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь жагсаалтад заасан бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд хамруулсны дараа зах зээлд нийлүүлэх буюу улсын хилээр нэвтрүүлнэ. <b>3.2.5.</b> Олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр хүлээн зөвшөөрсөн тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээний баталгаат загвар. <b>3.5.</b> Энэхүү журмын 1.7-д хамаарах бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт, сорилт шинжилгээ давтан хийхээс чөлөөлнө.</p>

5	<p><b>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн заалт: 9.1.2.</b> машин механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, техникийн паспорттай байх; <b>10.1.</b> Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна. <b>10.3.</b> Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд засвар үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага тодорхой хугацаанд хийж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулна.</p>
6	<p><b>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн заалт: 11.1.</b> Хэрэглэгч, үйлдвэрлэгч, гүйцэтгэгч бараа худалдах, худалдан авах, нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх тухай гэрээг бичгээр болон амаар хийж болно. <b>12.2.</b> Худалдагч барааг худалдаанд гаргахдаа үйлдвэрлэгч /нийлүүлэгч/-ээс энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан бараа нийлүүлэх талаар зохих гэрээг байгуулсан байна. <b>13.2.</b> Бараа, ажил, үйлчилгээг зах зээлд нийлүүлэхдээ түүнийг хэрэглэх заавар, хадгалах, тээвэрлэх, ашиглахад дагаж мөрдөх аюулгүйн зааварчилгаа, анхааруулга, үйлдвэрлэсэн он, сарыг худалдааны баримт бичиг, хаяг, шошго дээр хэрэглэгчид ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байхаар тусгана.</p>
7	<p><b>"Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийн заалт: 1.9.</b> Гадаад оронд үйлдвэрлэгдсэн лифтийн техникийн бичиг баримт нь монгол эсвэл орос, англи хэл дээр орчуулагдсан байна. Цахилгаан, шингэний схемийн таних тэмдэг нь олон улсын стандартын шаардлагад бүрэн нийцсэн байна</p>
8	<p><b>"Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийн заалт: 2.1.1.</b> Ачаа өргөх машин, түүний эд ангийг (зангилаа, механизм, ослоос хамгаалах хэрэгсэл, краны зам) үйлдвэрлэхэд шаардлагатай зураг төсөл боловсруулах ажлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага боловсруулна. <b>4.3.</b> Краныг худалдан авах байгууллага нь хяналтын байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр, түүний паспорт, засвар, ашиглалтын болон угсралтын баримт бичгийг монгол, орос, англи хэл дээр хөрвүүлж энэхүү дүрэм болон MNS ISO 7363-ын шаардлагад нийцүүлсэн байх ёстой.</p>